

БЯЦХАН “ОРШИЛ”-ООС ҮҮДЭН САНАЖ СЭДЭХҮЙ

Д.Хүүхэнбаатар

Нэрт эрдэмтэн Х.Нямбуу агсаны “Монголын угсаатны зүйн удиртгал” гэдэг сайхан ном 1994 онд нийтийн хүртээл болж хэвлэгдсэн.

Өчүүхэн миний бие энэ бүтээлийг хянан нягтлах завшаан тохиолдсон юм.

“Монголын угсаатны зүйн судалгааны товч”-ийг оршилдоо базаж нягтлан тоймлон гаргахдаа Монголын түүх, түүхэн угсаатны зүйн шинжлэл судалгааны олон ончтой шинэлэг судагааны дүгнэлт сэдэж дэвшүүлсэн асуудлуудын ач холбогдолын тухайд төдийгүй судлаачийн эрдмийн ухааныг тайлан тайлбарлаж олны хуртээл богох нь зүйтэй байна. Манайд эртний ийм уламжлал бий.

Ер нь манай, түүний дотор МУИС-ийн түүх, угсаатны зүйн тэнхмүүдийн олон эрдэмтдийн бүтээлүүд гарч байгаа боловч нэг ч шүүмж үгүй, сургалтанд юуг нь нэвтрүүлэх тухайд бага анхаарч байх шиг санагддаг. Үүний учир их эрдэмтдийн ухааны гайхамшигийг энэхүү бяцхан оршил дахь материалаас нь сэдэн, түүнийг нягтлан чухал санааг авч ухааныг ухааран хэрэглэх бяцхан оролдлого хийлзээ.

Монголын угсаатны зүйн энэхүү судалгаанд тулгуурлаж монгол угсаатны бүрэлдэхүүн нь гарвал зүйг багцалсан судалгааны ба хялбарчилсан сонин аргыг ухаалаг хослон хэрэглэжээ.

Монгол угсаатны зүйн хөгжлийн үечлэлийг шинэчлэн тогтоожээ. XIX зууны II хагаст Монголын угсаатны судалгаа эхэлсэн. Тэр нь гадаадын Оросын эрдэмтэд, жуулчид суурийг нь тавьж өгсөн гэж үзжээ. Энэ нь I үе болж байна.

Өрнөдийн онол сургаал нэвтэрч, монголын нийгэмд тэр үед гарч байсан шинэ үзэгдэл гарахтай давхцан, орчин цагийн судалгаа явуулах болсон нь XX зууны эхнээс 1950-1960-аад онд түүхэн угсаатны бүтээлүүд гарсныг тэмдэглээд гүнзгийрүүлсэн судалгаанд орсон З дахь үе болгожээ.

Зохиогч С.Бадамхатаны цаатан, дархад ястны тухай зохиол нь Монголын ястан, угсаатнуудын нарийвчлан судлах туршлага гэж үнэлэн, угсаатны зүйн мэдлэг дэлгэрсэн явдал ажээ.

IV үе нь 1970-1980-аад онуудаас хойш угсаатны судлалд мэргэжлийн боловсон хүчин төлөвшиж, нарийвчилсан судалгаа хийгдэж, Монголын (халхын) угсаатны зүйн тухай чансаатай бүтээл цэгцэрэн гарсан энэ сүүлийн үедээ өөдрөг енгөлөг санаа дэвшүүлжээ. Ингэснээр Монголын угсаатны зүйн байдлыг системчлэн гаргасан байна.

Монголын угсаатан судлалын цаашдын төлөв, зорилтоо Монгол угсаатны бүрэлдэхүүн, гарвал зүйг судлан өгүүлж цаашдаа угсаа-нийгийн болон угс аа-соёлын асуудлыг шинжих нь өнөөгийн угсаатан судлалын гол чиг баримтлал болгон дэвшүүлжээ.

Энэ дүгнэлт нь одоогийн Монголын угсаатны зүйн мөрдлөг болж байна. Бас нэг чухал нь монголчуудын эртний өвөг дээдсийн тухай асуудлыг авч үзэх дээ “Бида” улсын тухай зоригтой хэлж, хүннүчүүд палеосибирийн болон Төв Азийн хэв маяг хамарагддаг Монголын эртний өвөг дээдэс мөн гэсэн чухал дүгнэлт хийжээ.

Нэрт судлаач “Хүннү улс нь нийгмийн хөгжлөөрөө анхан шатны боол эзэмшигч, феодалын өмнөх үеийн шинж бүхий улс” хэмээн цоо шинэ дүгнэлт өгснийг онцлон тэмдэглүүштэй.

Энэ талаар нэгэн мөр болоогүй байгаа нөхцөлд судлаачийн санааг сургалт, судалгаандаа айхавтар харгалзах зүйтэй. Энэ бол монголчуудын эртний өвөг дээдэс, угсаа гарвалыг нягтлан, бас хялбарчлан толилуулсан байна.

Монголын угсаатан судлалаар гадаад орнуудад хийж байгаа судалгаанд үнэлэлт цэгнэлт өгчээ.

Түүхэн хэл зүйн үүднээс тансаг сайхан нэр томъёо хэрэглэсний нэг жишээ нь "Оршиж очих" гэдэг өгүүлэлмжээс нь тодорхой. Энэ бол нүүдэлчдийн нүүдэл суудал, эртний овог аймгуудын тухайд гайхмаар онож хэлжээ.

Эцэст нь хэлэхэд энэ бяцхан оршилд ихийг багтааж Монголын угсаатны зүйн судалгааг базаж нягтлан системч лсэн байна.

Ийнхүү санаа сэдсэний учир шүүмжийг хөгжүүлье. Шүүмж гэдэг хар хэл ам биш, ухааныг илчлэх задлан тайлбарлах судалгааны нэг төрөл гэдгийг сэдье.

Та бүхнийг үүнд дуудаж нэгийг залуу дүү нартаа мэдүүлэн ухаантныг хойно нь мэддэг муугаас бид салья.

Эрдэм судлалын чансаатай сайн ном бүтээлүүдээ түмнээ хялбаржуулсан шүүмж, задлан тайлах ажлыг гүнзгийрүүлье.

Ном зүй

1. Х.Нямбуу "Монголын угсаатны зүйн удиртгал" УБ., 1994
2. Мөн 3-6 дугаар тал
3. Б.Буянчуулган Монгол өөлдийн түүх, гар бичмэл УННС. Б.Буянчуулган. Монголын тариалангийн түүх, гар бичмэл УТТА. Г.Бадрах Монгол хувцасны өгүүлбэр, гар бичмэл УННС. Г.Бадрах. Монголын хөгжмийн түүхээс. УБ., 1962.
- Х.Магсаржав. Долоон хошуу наадам , нгангаайтлүүлсэн Ч.Хасдорж УБ., 1960
- Ж.Цэвээн, Дархад, Хөвсгөлийн Урианхай, Дөрвөд, Хотон, Баяд,Өөлд, Мянгад, Захчин, Торгууд, Цахар, Дарьганга, Алтайн Урианхай, Хасаг, Хамниган нарын үүсэл гарлын өгүүлэл. УБ., 1924
4. Д.Гонгор. Ховдын хураангуй түүх. УБ., 1964
Д.Гонгор. Халх товчоон. 2 боть. 1970, 1978 он
Н.Сэр-Оджав. Эртний Түрэгүүд (VI-VIII зуун) УБ., 1970
Н.Сэр-Оджав. Монголын эртний түүх. УБ., 1977
Х.Пэрлээ. Хятан нар, тэдний монголчуудтай холбогдсон нь. УБ., 1959
Х.Пэрлээ. Монгол түмний гарлыг тамгаар хайж судлах нь УБ., 1976
С.Пүрэвжав. Монгол дахь шарын шашны хураангуй түүх. УБ., 1979
С.Пүрэвжав. Хотгойдын угсаа ба түүний асуудалд. УБ., 1970
Г.Сүхбаатар. К вопросу об этногенезе монголов "Төв Азийн иргэншилд нүүдэлчдийн роль. УБ., 1974. 271-277 дахь тал
Б.Ринчэн. Удирдан нийтлүүлсэн Монгол ард улсын угсаатны судлал-хэл шинжлэлийн атлас. УБ., 1979
Г.Цэрэнханд. Хөдөө аж ахуйн нэгдэлчдийн өрх гэр, аж ахуйн этнографийн судлал. УБ., 1972
Г.Батсайхан. БНМАУ дахь нэгдэлчдийн аж ахуйгаа хөтлөх арга ажиллагаа. УБ., 1978
Х.Нямбуу. Халхын зарим нутгийн хээ угалзны зүйлээс (XIX-XX зууны эхэн) SE Т Ш УБ., 1968
Өнөөгийн монгол ёс.УБ., 1979
Монголын билэгдэл. УБ., 1979
БНМАУ-д социалист ёс заншил төлөвшсөн нь УБ., 1984
Хамгийн эрхэм ёсон. УБ., 1970
Монголын угсаатны зүйн удиртгал. УБ., 1992
Х.Сампилдэндэв. Монгол ардын хуримын яруу найраг. УБ., 1980
5. Х.Нямбуу. Монголын угсаатны зүй. Удиртгал. УБ., 1992. 38 дахь тал